

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ**
(Энгийн хувилбар)

- ХАРИУЦЛАГА
- ХЯНАЛТ-ТЭНЦЭЛ
- ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

АЖЛЫН ДЭД ХЭСГҮҮД
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ

I. УЛСЫН ИХ ХУРЛЫН ХАРИУЦЛАГА, ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

Нэг.Улсын Их Хурлын гишүүний хариуцлагыг дээшлүүлэх:

1.1.Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах

29.4.Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгааг Үндсэн хуулийн цэц тогтоосон бол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.

1.2.Улсын Их Хурлын гишүүний насны доод хязгаарыг нэмэх

21.3.Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын гучин нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.

Хоёр.Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагааг боловсронгуй болгох:

2.1.Улсын Их Хурлын бие даасан, хараат бус байдлыг хангах

25.4.Улсын Их Хурлын зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хууль тогтоомжоор тогтооно.

2.2.Улсын Их Хурал хууль тогтоох байнгын буюу тасралтгүй ажиллах байгууллага байх нөхцөл шалгуурыг хангах

27.2.Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа далан таваас доошгүй ажлын өдөр чуулна. /2000 оны өөрчлөлттэй холбоотой/

2.3.Асуудлыг олонхоор шийдэх ардчиллын зарчмыг хангах

27.6.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуулийг Улсын Их Хурлын нийт гишүүний олонхийн саналаар эцэслэн батална.

Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргаж асуудлыг шийдвэрлэнэ. Үндсэн хууль, бусад хуульд заасан, эсхүл хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжсэн бол нууц санал хураалт явуулна. /2000 оны өөрчлөлттэй холбоотой/

2.4.Улсын Их Хурлын гишүүн өөр ажил, албан тушаал хавсрахыг хориглох

29.1.Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол албан үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй. /2000 оны өөрчлөлттэй холбоотой/

Гурав.Улсын Их Хурлын бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болох:

22.2.Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж Улсын Их Хурал шийдвэрлэсэн бол Улсын Их Хурал тарна.

22.3.Улсын Их Хурлын анхдугаар чуулганы хуралдаан эхэлснээс 45 хоногийн дотор, Ерөнхий сайдыг шинээр томилох нөхцөл үүссэн

тохиолдолд 30 хоногийн дотор Ерөнхий сайдыг томилоогүй бол Улсын Их Хурлыг тараах шийдвэрийг Ерөнхийлөгч гаргана.

22.4. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасны дагуу шийдвэр гаргаснаас хойш Улсын Их Хурал 10 хоногийн дотор сонгуулийг товлон зарлах бөгөөд сонгуулийг 60 хоногийн дотор явуулна. Шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ хадгална. /2000 оны өөрчлөлттэй холбоотой/

Дөрөв.Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн хяналт-тэнцлийг сайжруулах зорилгоор Улсын Их Хурлын зарим бүрэн эрхийг хязгаарлах:

4.1.Улсын Их Хурал сайд нарыг томилох бүрэн эрхээсээ татгалзах

25.1.6. “Засгийн газрын гишүүд,” гэснийг хасах.

4.2.Төсвийн талаарх Улсын Их Хурлын бүрэн эрхийг хязгаарлах

25.1.7. төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах. Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа Засгийн газрын зөвшөөрөлгүйгээр зардлын шинэ төрөл үүсгэх, зарлага нэмэгдүүлэхийг хориглоно;

Тав.Улсын Их Хурлын хяналтыг боловсронгуй болгох:

28.3. Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна.

28.4. Хянан шалгах түр хороо нь холбогдох хууль тогтоомжийн дагуу мэргэжлийн, хараат бус шинжээч томилох, гэрч дуудах, тайлбар, мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах бүрэн эрхтэй. Түр хороо дүгнэлт гаргаж, шаардлагатай бол тухайн асуудлыг эрх бүхий байгууллагад шалгуулахаар шилжүүлж болно. Түр хорооны дүгнэлт шүүхэд үүрэг хүлээлгэхгүй. Хорооны хэлэлцсэн баримтыг нотлох баримтад тооцох эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

28.5. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа асуудлаар хянан шалгах түр хороо байгуулахгүй. Нэг асуудлаар нэгээс илүү тооны хянан шалгах түр хороо байгуулахыг хориглоно.

28.6. Хянан шалгах түр хороо байгуулах, ажиллах журмыг хуулиар тогтооно.

Зургаа.Улсын Их Хурлын сонгуультай холбоотой заалт:

21.4. Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоо, журмыг хуулиар тогтооно. Улсын Их Хурлын сонгуульд иргэн бие дааж, эсхүл нам нэр дэвшүүлж оролцоно. Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.

33.1.2/ Улсын Их Хуралд олонхи суудал авсан намаас нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам бусад намтай зөвшилцөн олонхийг бүрдүүлж нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам бусад намтай зөвшилцөн Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам бусад намтай зөвшилцөн олонхийг бүрдүүлж нэр дэвшүүлсэн хүнийг

Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах; /2000 оны өөрчлөлттэй холбоотой/

II. ГҮЙЦЭТГЭХ ЭРХ МЭДЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

Нэг. Засгийн газрыг эмхлэн байгуулах:

39.2. Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Ерөнхий сайд энэ асуудлыг Ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ.

39.3. Ерөнхий сайд нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулснаар Засгийн газрын гишүүнийг томилж, чөлөөлж, огцруулна.

Хоёр. Ерөнхий сайдыг огцруулах журам:

43.1. Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулж, шинэ Ерөнхий сайдыг томилох тухай саналыг хамтад нь албан ёсоор тавибал Улсын Их Хурал 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэнэ. Улсын Их Хурлын нийт гишүүний олонхи уг саналыг дэмжсэн бол шинэ Ерөнхий сайдыг томилох, өмнөх Ерөнхий сайдыг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцно.

43.2. Ерөнхий сайд огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.

Гурав. Ерөнхий сайд өөрт нь итгэл үзүүлэхийг хүсэх:

44.1. Ерөнхий сайд улсын төсөв, бодлогын тодорхой асуудлаар өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулбал Улсын Их Хурал 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ.

44.2. Улсын Их Хурал тогтоолыг баталсан бол Ерөнхий сайдад итгэл үзүүлж, тухайн асуудлыг дэмжсэнд тооцно. Тогтоолыг батлаагүй бол Ерөнхий сайдыг огцорсонд тооцож шинэ Ерөнхий сайдыг 30 хоногийн дотор томилно.

Дөрөв. Засгийн газрын гишүүн Улсын Их Хурлын гишүүнээр хавсран ажиллахыг хязгаарлах:

39.1. Засгийн газар Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдээс бүрдэнэ. Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно. /2000 оны өөрчлөлттэй холбоотой/

Тав. Төрийн албаны зарчмыг тодорхойлох, улс төрийн шалтгаанаар төрийн албанаас халах, чөлөөлөхийг хориглох, шатлан дэвших, чадахуйн (мерит) зарчимд суурилсан хариуцлагатай томилгоог бий болгох:

46.4. Төрийн жинхэнэ алба нь мэргэшсэн, тогтвортой, хариуцлагатай байх, шатлан дэвших зарчимд үндэслэнэ. Төрийн албан хаагчийг улс төрийн шалтгаанаар ялгаварлан гадуурхах, сонгуулийн үр дүнгээр, эсхүл хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албанаас халах, чөлөөлөхийг хориглоно. Төрийн албаны чадахуйн зарчмын хэрэгжилтэд тавих хяналт хараат бус байна.

III. ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН ХАРИУЦЛАГА, ХАРААТ БУС БАЙДЛЫГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

Нэг.Шүүгчийн мэргэшсэн, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх, томилгоог ил тод болгох, бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгчийг шүүгчид өөрсдөө сонгодог болох:

51.2.Шүүхийн ерөнхий зөвлөл бүх шатны шүүхийн шүүгчийг томилох шийдвэрээ Ерөнхийлөгчид хүргүүлнэ. Ерөнхийлөгч энэ шийдвэрийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор батламжилна. Үндсэн хуульд заасан шаардлага хангаагүй гэж үзвэл Ерөнхийлөгч шүүгчийг батламжлахаас татгалзаж, үндэслэлээ нийтэд мэдээлнэ. Улсын дээд шүүхийн шүүгчийг томилохдоо томилгооны сонголд оруулж, томилох шийдвэрээ Улсын Их Хуралд танилцуулж, Ерөнхийлөгчид хүргүүлнэ.

51.3.Хууль зүйн дээд боловсролтой, хуульчийн мэргэжлээр таваас доошгүй жил ажилласан, гучин нас хүрсэн Монгол Улсын иргэнийг анхан шатны шүүхийн шүүгчээр томилж болно. Давж заалдах шатны шүүхийн шүүгч нь тухайн шүүн таслах ажлын төрлөөр дагнан анхан шатны шүүхэд зургаагаас доошгүй жил шүүгчээр ажилласан байна. Хууль зүйн дээд боловсролтой, хуульчийн мэргэжлээр арван таваас доошгүй жил ажилласан, дөчин нас хүрсэн Монгол Улсын иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр арван хоёр жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа томилно.

51.5.Бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгчийг тухайн шүүхийн шүүгчдийн дотроос нийт шүүгчдийн олонхийн саналаар гурван жилийн хугацаагаар сонгоно. Ерөнхий шүүгчийг тухайн шүүхэд нэг удаа улируулан сонгож болно.

Хоёр.Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох:

49.5.Шүүхийн ерөнхий зөвлөлийг дараахь журмаар байгуулна:

1/Шүүхийн ерөнхий зөвлөл арван гишүүнээс бүрдэнэ. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэгэн бүрэн эрхийн хугацаанд ажиллана;

2/Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо нэр дэвшүүлж, Улсын Их Хурал томилгооны сонголд хийж, хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар томилно. Тэдгээр нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан Монгол Улсын иргэн байна;

3/Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн нэгийг хяналтын шатны шүүхийн шүүгчдээс, нэгийг давж заалдах шатны шүүхийн шүүгчдээс, гурвыг анхан шатны шүүхийн шүүгчдээс тус бүр дундаасаа сонгоно;

4/Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо нэр дэвшүүлж, нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.

Гурав.Шүүгчийн хариуцлагын зөвлөл байгуулах:

49.6.Шүүгчийн хариуцлагын зөвлөл нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, чөлөөлөх, огцруулах болон бусад шийтгэл ногдуулах шийдвэр гаргана.

49.7.Шүүгчийн хариуцлагын зөвлөл 9 гишүүнээс бүрдэнэ. Шүүгчийн хариуцлагын зөвлөлийн гишүүн нь 6 жилийн хугацаагаар зөвхөн нэгэн

бүрэн эрхийн хугацаанд ажиллана. Шүүгчийн хариуцлагын зөвлөлийг дараахь журмаар байгуулна:

1/Гишүүдийн гурвыг иргэдээс; гурвыг хууль зүйн өндөр мэргэшилтэй, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан эрдэмтдээс тус тус сонгон шалгаруулж Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо нэр дэвшүүлэн Улсын Их Хурал хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар томилно;

2/Гишүүдийн нэгийг хяналтын шатны шүүхийн шүүгчдээс, нэгийг давж заалдах шатны шүүхийн шүүгчдээс, нэгийг анхан шатны шүүхийн шүүгчдээс тус бүр дундаасаа сонгоно;

3/Шүүгчийн хариуцлагын зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо нэр дэвшүүлж, нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.

49.8. Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүгчийн хариуцлагын зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.

IV. НУТГИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХТОЙ ХОЛБООТОЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

Нэг. Хотын эрх зүйн байдлыг тодорхой болгох:

57.2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. Хотод засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эрх хэмжээг эдлүүлж болох бөгөөд энэхүү асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

Хоёр. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг тодорхойлох:

58.1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь хуулиар тусгайлан олгосон чиг үүрэгтэй, иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцох эрхтэй засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж мөн. Баг, хороо нь засаг захиргааны анхан шатны нэгж мөн.

Гурав. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн байдлыг тодорхойлох:

59.2. Монгол Улсын нутгийн өөрийн удирдлагын үндсэн нэгж нь сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал мөн. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд татвар тогтоох, өмчийн эрхтэй байна. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тоо, тэдгээрийг иргэд сонгох журмыг хуулиар тогтооно.

59.3. Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурал нь сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас дөрвөн жилийн хугацаагаар сонгогдсон төлөөлөгчдөөс бүрдэнэ.

59.4. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал нь тухайн нутаг дэвсгэрт хамаарах асуудлаар хуульд заасан болон сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон бүрэн эрхийн хүрээнд шийдвэр гаргана.

Дөрөв. Бүх шатны Засаг даргыг томилох, огцруулах журмыг тодорхойлох:

60.1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хэрэгжүүлнэ. Бүх шатны Засаг даргын бүрэн эрх батламжилсан буюу томилсноор эхэлж, дараагийн Засаг даргын бүрэн эрх эхэлснээр дуусгавар болно.

60.2. Аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд; баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилж, хуульд заасан үндэслэлээр чөлөөлж, огцруулна.

60.3. Сум, дүүргийн Засаг даргыг тухайн нутаг дэвсгэрийн иргэд дөрвөн жилийн хугацаагаар сонгож, аймаг, нийслэлийн Засаг дарга арван тав хоногийн дотор батламжилна. Сонгуулийн журмыг хуулиар тогтооно.

60.4. Хуульд заасан үндэслэлээр аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурлын нийт төлөөлөгчдийн олонхийн саналаар аймаг, нийслэлийн Засаг даргыг огцруулах саналыг Ерөнхий сайдад, баг, хорооны иргэдийн дөрөвний нэгээс доошгүй нь баг, хорооны Засаг даргыг огцруулах саналыг сум, дүүргийн Засаг даргад өргөн мэдүүлсэн бол арван тав хоногийн дотор уг асуудлыг шийдвэрлэнэ. Засаг даргыг огцруулах шийдвэр гаргасан тохиолдолд үлдсэн бүрэн эрхийн хугацаагаар нөхөн томилох асуудлыг арван тав хоногийн дотор энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

60.5. Сум, дүүргийн Засаг даргыг хуульд заасан үндэслэлээр огцруулах саналыг аймаг, нийслэлийн Засаг дарга сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулсан бол арван тав хоногийн дотор уг асуудлаар Хурал шийдвэр гаргаж, хариу мэдэгдэнэ. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сум, дүүргийн Засаг даргыг огцруулах шийдвэр гаргасан тохиолдолд бүрэн эрхийн үлдсэн хугацаанд ажиллах Засаг даргыг аймаг, нийслэлийн Засаг дарга томилно.

V. НАМЫН ЧИГ ҮҮРЭГ, САНХҮҮЖИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧМЫГ ТОДОРХОЙЛОХТОЙ ХОЛБООТОЙ НЭМЭЛТ

19¹.1. Нам иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлж, үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулна.

19¹.2. Намын дотоод зохион байгуулалт нь ардчилсан зарчимд нийцсэн байх бөгөөд хөрөнгө, орлогын эх сурвалж болон зарцуулалтаа нийтэд байнга ил тод байлгах үүрэгтэй. Намын зохион байгуулалт, үйл ажиллагаа, санхүүжилт, ил тод байдал, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх болзлыг хуулиар тогтооно.

VI. ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ГИШҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ, ХАРААТ БУС, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДЛЫГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

65.1. Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор томилгооны сонголт хийж Улсын Их Хурал нийт гишүүний олонхийн саналаар есөн жилийн хугацаатай томилно. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр дахин томилохыг хориглоно.

65.2. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүйн өндөр мэргэшилтэй, мэргэжлээрээ арван таваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэнийг томилно.

Дагаж мөрдөх хугацаа:

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 12.00 цагаас эхлэн улс даяар дагаж мөрдөнө.

Үндсэн хуулийн 51.3 дахь хэсэгт оруулж байгаа нэмэлт, өөрчлөлт нь 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө томилогдсон шүүгчдэд, Үндсэн хуулийн 65.1, 65.2 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлт нь 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө томилогдсон Үндсэн хуулийн цэцийн гишүүдэд хамаарахгүй.

---o0o---

Ажлын дэд хэсгүүд